

ДеФакто **ТОЙМ**

➤ ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ХИЙХЭД БЭЛЭН ҮҮ?

➤ СОНГУУЛИЙН ХУУЛЬ “БАНТАН”  
БОЛОХ ҮҮ?

➤ 70 КГ ХАР ТАМХИ ЗӨӨВӨРЛӨСӨН  
ДИПЛОМАТУУД ХЭН БЭ?

V НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан  
Эдийн засагч, нийтлэлч

# ХАР | ЦЭНХЭР ТАМХИ | ПАСПОРТ

II НҮҮРТ

WEEKLY

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.06.13, №9 (101)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,  
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,  
<http://jargaldefacto.com/category/23>

# ХАР | ЦЭНХЭР ТАМХИ | ПАСПОРТ

**2019** оны 5-р сарын 3-нд Германы Дрезден хотод монголын дипломат дугаартай автомашиныг саатуулан шалгахад 70 кг героин-мансууруулах бодис илэрчээ. Туркийн Станбул хотод суугаа монголын дэд консул Б.Баттүшиг, жолооч С.Эрдэнэбаяр нар Чехээр дайрч ирээд ийнхүү саатуулагджээ.

## ХАР ТАМХИ

Монголчууд эртнээс хар тамхи гэж нэрлэж ирсэн энэ бодис нь хүний уураг тархи, мэдрэлийн системд нөлөөлдөг ургамлын гаралтай мансууруулдаг чанартай. Дотроо каннабиноид, марихуан, гашиш гэх мэт олон төрөлтэй энэ бодисыг химийн аргаар ч бас гаргаж авдаг. Бүх хар тамхинд THC (tetrahydrocannabinol) гэдэг бодис байдаг. Энэ бодис хүний уураг тархинд шууд нөлөөлж, адреналлинийг ихэсгэж, донтуулдаг дофамины хэмжээг эрс өсгөснөөр хүн биеэ барих чадвараа алддаг. Улмаар нисэж байгаа мэт мэдрэмж төрж, сэтгэл санаа огцом дээшилж, хэт хөөрөх, бэлгийн харьцаанд орох хүсэл төрүүлж, эсвэл сэтгэл санаа огцом унаж, уурлах, бие эрхтнээ гэмтээх, үхэх, амиа хорлох хүсэл төрүүлдэг ажээ.

Хар тамхийг хэрэглэх тусам донтож, бие махбодийг хамрах хүрээ нь өргөжинө. Тархин дахь дааврын хэмжээ өөрчлөгдөж, эдийг үхүүлж, мэдээлэл хадгалах, санах ойд нөлөөлж, сэтгэх үйл ажиллагааг доголдуулж,

Сүүлийн үед хар тамхи хэрэглэсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хүлээн авсан олон хэрэг цувран гарч, монголын нийгмийг цочирдуулсаар. Хар тамхины эдгээр хэргүүд яагаад гараад байгаа, яг ямар хор уршиг тарьж байгаа, яавал зогсоох талаар гуравхан сая монголчууд яаралтай хэлэлцэж, үр хүүхэд, эх орныхоо ирээдүйг хамгаалах шаардлага тулгарлаа.

сэтгэцийн эмгэг үүсгэдэг. Харах, үнэрлэх, сонсох мэдрэхүүд нөлөөлж, хий юм харж, чих шуугидаг. Ходоод гэдэсний хэвийн үйл ажиллагаа алдагдаж, хоолны дуршил буурснаар шим тэжээлийн дутагдалд орж, турж эцэн, арьс харлаж, үс унаж, хурдан өтөлнө.

Хар тамхи татсанаас нэг минутын дотор зүрхний цохилт минутад 20-50-аар нэмэгдэж 20-180 минут үргэлжилнэ. Салгалан чичрэх, уур хүрч, бухимдах бөгөөд мансуурал нь зогсмогц толгой хүчтэй эргэх, харааны төвлөрөл алдагдах, сульдаж ядрах, нойргүйдэх, сэтгэл гутралд автах зэрэг шинж тэмдгүүд үлддэг. Цус нь тэгж бохирдсон учраас хүн донтож, мансууруулах бодис хүсч, олж авахын төлөө юу ч хийхээс буцахгүй болдог.

Хар тамхи анх удаа хэрэглэсэн хүмүүсийн зөвхөн тавны нэг нь мартаж чаддаг бол бусад нь дахин хэрэглэхийг хүсдэг байна.

## ЦАГААН ТАХАЛ

*Монгол улс 2016 оноос хар тамхины хэрэгтэй холбоотой мэдээллийн сан байгуулж одоо 1500 орчим хүнийг бүртгээд байна. Учир нь 2015 оноос Монгол улс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлдөг бодис буюу хар тамхины хэрэглэгч орон болжээ. Манай оронд мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байна. 2014 онд 61 хэрэгт 153 хүн холбогдсон бол жил бүр өссөөр 2018 онд 199 хэрэгт 412 хүн холбогдуулан шалгасны 337 эрэгтэй, 75 эмэгтэй, тэднээс 6 нь насанд хүрээгүй хүүхдүүд байна.*

▶ Хар тамхийг хэрэглэхээс гадна зарж борлуулвал их хэмжээний мөнгө хурдан олж болдог гэх шунал нийгэмд газар авч байна. Хар тамхийг гадаадаас хил гаалиар ачаа тээш, биедээ тээвэрлэн оруулахаас гадна шуудан, илгээмжээр авах болов.

Тагнуулын ерөнхий газрын мэдээгээр дэлхийд хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн сүлжээ болох Тайланд, Лаос, Мьянмарын “алтан гурвалжин” гэх гэмт бүлэглэлд манай иргэдээс нэгдээд байна. Гол төлөв Зүүн өмнөд Азийн орнуудад байгаа манай оюутан залуус, биеэ үнэлэгчид тээвэрлэгчийн үүрэг гүйцэтгэж байна. Иргэдийн амьжиргааны түвшин доогуур, хар тамхины тухай мэдлэг, мэдээлэл дутмаг, бүс нутгийн ихэнх орнуудад визгүй зорчдог учраас монголчууд энэ гэмт хэрэгт хамрагдсаар байна. Манай иргэдийн холбоотой хар тамхины дийлэнх хэрэг урд хөршид, дийлэнх нь хил залгаа Эрээнд үйлдэгддэг.

Дамжин өнгөрч буй хар тамхины 20 хувь нь тухайн оронд үлддэг гэсэн олон улсын судалгаа байдаг. Хүүхдүүд хар тамхины талаар мэдлэг дутмаг, хэт сониуч зангаасаа гэмт хэргийн золиос болж, бусдын нөлөөгөөр хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж байна. 2018 онд 1000 гаруй хүүхдээс судалгаа авахад дөрөвний нэг нь мансууруулах бодис “хэрэглэдэг”, бүр ангиараа хэрэглэж байсан гэж “Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг” мэдээлжээ. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчдийн дийлэнх нь 18-

20 гаруй насныхан бөгөөд эмчлүүлэгчдийн тоо 2018 онд гурав дахин нэмэгджээ.

Хар тамхины хэрэг улам бүр дэлгэрч буйгийн бас нэг шалтгаан бол манай улсад ял шийтгэлээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой. Тухайлбал, УИХ-ын гишүүн асны хүү тээврийн прокурор Х.Т гэгч хар тамхи татаж байгаад 2015 оны 7-р сард баривчлагджээ. 2017 оны 1-р сард түүнд шүүхээс ял оноохдоо хар тамхины хэргийг нь өршөөж, авлигын хэрэгт нь ял оноож байв. Тэр энэ ялыг давж заалджээ. Төдөлгүй хэрэг нь замхарч, Х.Т нь өмгөөлөгчийнхөө хамт хар тамхи дахин хэрэглэж байх үедээ баригдав.

Мөн иргэн Г.Сарангэрэл зэрэг хүмүүсийг урд хилээр хар тамхи ичимдэг эрхтэндээ тээвэрлэн оруулж ирэхэд нь саатуулсан. Энэ нь Г.Сарангэрэлийн хувьд хар тамхины гурав дахь удаагийн хэрэг. Эхний удаад өөрөө хэрэглэсэн, дараа нь борлуулсан бол, сүүлд нь гадаадаас тээвэрлэжээ.

*Монгол улс хуулиа хэрэгжүүлж зохих ял шийтгэл эдлүүлж чадахгүй байгаа учир гэмт хэргийг давтан үйлдэх боломж олгосоор байна. Монгол улсын эрүүгийн хуулийн 192-р зүйлд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах” гэмт хэрэг үйлдсэн бол 15 жил хүртэл хорих ялаар шийтгэдэг. Хэн ч энэ ялаа гүйцэд эдлэж байгаагүй ажээ.*

## ЦЭНХЭР ПАСПОРТ

Монголын дипломат паспортын хавтас цэнхэр өнгөтэй. Ийм паспортоо тамхины, хар тамхины хууль бус наймаа эрхлэн улс орнуудын хил дамжин зөөхдөө ашигладаг талаараа манай дипломатууд Европт “алдаршсаар” байна. Тэд тэгж “мандахын” хэрээр, эгэл жирийн монгол иргэдийн нэр хүнд унасаар байна.

2000 оноос “Блэк Морган” нэртэй сүлжээ ажиллаж ижил нэртэй тамхийг Европ даяар цэнхэр паспортоороо халхавчлан зөөдөг байжээ. Тэдний “загалмайлан эцэг” гэгдэх Болгар дахь Монголын Элчин сайдын зөвлөх асан Д.Шатарбал 2005 оны 3-р сарын 23-нд Болгарын тусгай албаныханд баригдсан. Тэр дипломат дугаартай албаны машиндаа 23 сая доллартай тэнцэх 120 кг хар тамхи тээвэрлэж явжээ. Тэрээр монголд ял авсан ч, Ерөнхийлөгчийн өршөөлөөр суллагдсан. Монголоос хичнээн олон элчин сайд, зөвлөх, консул, атташе цолтой, цэнхэр паспорттой тамхины наймаачид төрснийг [сайтуудаас](#) харж болно.

Улс орныхоо нэр хүндийг сэвтүүлж, гадаадын оронд ял шийтгэл хүлээж, нутагтаа хөөгдөж ирчихээд юу ч болоогүй мэт, төр засгийн өндөр албан тушаал хаших нь хэвийн үзэгдэл болжээ. Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газар хамтран цэнхэр паспорттой хар тамхины наймаачдаа цэгцлэх цаг болжээ.

Монгол улс хар тамхины гэмт хэрэгтэй өгөөжтэй тэмцэхийн тулд хилийн хяналт, цагдаагийн ажилтнуудаа чадавхжуулах, хил гаалийн байгууллагын хяналтын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай. Монгол улсад каннабисийн төрлийн ургамал өргөн тархсан байгааг устгах, нийгэмд хар тамхины хор уршгийн талаар ухуулга сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах хэрэгтэй байна. Энэ бүхнийг шуурхай хэрэгжүүлэхгүй бол хар тамхи хорт хүрээгээ тарааж тэлсээр, айл бүрийг хамран “самарч” нэг л мэдэхэд “цагаан тахал” -д нэрвэгдсэн маргааш монголыг угтана.

# ДАРАА ТӨЛБӨРТ

шинэ хэрэглэгчид

БАРЬЦАА ТӨЛБӨР  
БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ

0 ТӨГРӨГ

## ЯРИА

Сүлжээндээ хязгааргүй  
**7.000₮**

Сүлжээндээ хязгааргүй  
Бусад сүлжээнд 250 минут  
**17.000₮**

Сүлжээндээ хязгааргүй  
Бусад сүлжээнд 1000 минут  
**27.000₮**

## ДАТА

Хязгааргүй 2GB  
**12.000₮**

Хязгааргүй 10GB  
**28.000₮**

Хязгааргүй 5GB  
**20.000₮**

Хурд, хэрэглээний хязгааргүй  
**42.000₮**

## МЕССЕЖ

Сүлжээндээ өдөр бүр 200ш  
**2.000₮**

Сүлжээндээ өдөр бүр 200ш  
Бусад сүлжээнд сард 500ш  
**4.500₮**





## ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:  
2019.06.09-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

## ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ХИЙХЭД БЭЛЭН ҮҮ?

### Үйл явдлын товч:

Монгол ардын нам засгийн эрхэнд гарсан цагаасаа хойш Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар идэвхтэй ярьсаар ирсэн. Улмаар 2017 оны 5-р сарын 5-ны өдрийн 78 дугаар захирамжаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Улсын их хуралд өргөн барих үүрэгтэй ажлын хэсгийг өмнөх УИХ-ын дарга М.Энхболдын үед анх байгуулж байсан. Тэгвэл өнгөрсөн Пүрэв гарагт их хурлын нийт гишүүдийн дөрөвний гурваас илүүгийн дэмжлэгтэй төслийг боловсруулж өргөн бариад байна.

### Дүгнэлт тайлбар:

Энэ их хуралд нэг нам 85 хувийн суудлыг авсан учраас энэ нам бүх хуульд, түүний дотор үндсэн хуульд өөрчлөлт хийх эрхтэй болсон ганц их хурал. Давхардсан тоогоор нийт 5.4 сая иргэнээс санал авч, эрдэм шинжилгээний хэд хэдэн хурал хийсэн, үндсэн хууль судлаач эрдэмтэд, хууль тогтоогчдын санал бодол, дүгнэлтийг ч мөн авсан гэж байгаа. Тэгээд үндсэн хуулийг өөрчлөө гээд төслийг нь бэлтгээд 67 гишүүн гарын үсэг зурсан байна. Тэгэхээр энэ бол хэлэлцэхээс зайлшгүй болсон гэсэн үг. Намар хийгээд батлах байх. Үндсэн хуулийн 6-р бүлэг, 69-р зүйлд нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулахын тулд УИХ-ын гишүүдийн 4-ний 3-ын саналаар хийнэ гэсэн заалт байгаа. Энэ бол 57 гишүүн гэсэн үг, харин эд 67-уулаа байна.

Улс төрд мөнгөний нөлөө маш их орсон учраас засаг тогтворгүй байгаа. Улс төрийн намуудын санхүүжилт нууц, хэн их мөнгө гаргасан тэр хүн нь илүү эрх мэдэлтэй болдог. Үндсэн хуульд энэ улс төрийн намын санхүүжилтийг ил тод байлгах тухай заалт оруулж байгаа. Мөн тэгснээр улсын төсвөөс санхүүжүүлнэ гэсэн байна.

Харилцан тэнцвэртэй байх тухай буюу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 засаглалд хууль тогтоогчдоос 18 нь гүйцэтгэх засаглал руу орж байгааг болиулаад 4 болгохоор хязгаарлалт хийж өгсөн. Ерөнхий сайд өөрөө кабинетаа бүрдүүлдэг барууны зарчмыг оруулж байгаа юм байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10 гишүүний 5-ыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод томилгооны сонголд оруулаад, нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар зөвхөн 1 удаа 4 жилийн хугацаагаар томилох заалтыг төсөлд тусгасан нь хараат бус байдал нь хэр байх вэ гэдэгт эргэлзээ төрж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг 1 удаа 9 жилийн хугацаатайгаар томилох, Ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаагаар зөвхөн 1 удаа сонгоно гэж байгаа.

## СОНГУУЛИЙН ХУУЛЬ “БАНТАН” БОЛОХ ҮҮ?

### Үйл явдлын товч:

Өнгөрсөн өдрүүдэд УИХ-ын сонгуулийг “улс нэг тойрог буюу 76 нэр дэвшигч”-ийг тодруулахаар болгож өөрчлөх тухай асуудал нийгэмд нэлээн яриа, хэлэлцүүлэг боллоо. 2015 онд Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуулиудыг нэг хуулиар зохицуулахаар болгож өөрчилж байсан. Гэтэл энэ удаагийн өөрчлөлтийг боловсруулаад буй хууль санаачлагчид Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуулиуд нь зайлшгүй тусдаа хуулиар зохицуулагдах ёстой гэсэн байр суурьтайгаар өөрчлөх гэж байна. Монгол Улс өнгөрсөн хугацаанд 7 удаа сонгууль зохион байгуулсан. Ингэхдээ 4 удаа можаритор, 1 удаа холимог, бусад нь томсгосон тойргийн тогтолцоогоор сонгууль хийсэн байна.

### Дүгнэлт тайлбар:

Явж үзээгүй зам төөрсөн хүнд хамгийн зөв байдаг гэдэг шиг л юм болж байна. Израйль улс ийм тогтолцоотой юм байна. Эерэг тал нь иргэд олон сонголттой болох юм. Харин техникийн хувьд яаж зохицуулах вэ гэдэг асуудал гарах байх. Сөрөг тал нь алслагдсан нутгийн төлөөлөл бага болчих болов уу гэж бодож байна.

Улс төрийн намын гишүүд арай том зарчмын юмаа ярьж эхлэх болов уу гэж бодож байна. Ил тод байдал, намын санхүүжилт, шийдвэр гаргалт гэх мэт арай илүү соёл иргэншилтэй юм ярьснаар бусдаасаа ялгарах болох байх. Сонгууль маргаантай болвол заримыг нь гараар тоолдог. Үүн дээр том ажил гарах л байх. Хар машингүйгээр сонгууль хийх боломжгүй. Санал худалдан авах боломж арай багасах байх.

Хууль тогтолцоог өөрчиллөө гээд зарчмыг өөрчилж чадахгүй. Хариуцлагатайгаар өөрөө сонголттой хийх хэрэгтэй.

## 70 КГ ХАР ТАМХИ ЗӨӨВӨРЛӨСӨН ДИПЛОМАТУУД ХЭН БЭ?

### Үйл явдлын товч:

Өнгөрсөн долоо хоногт монголын дипломат албаныхан 70 кг хар тамхи зөөвөрлөж байгаад Германы Дрезден хотод саатуулагдсан хэрэг нийгмийн сүлжээгээр хурцаар яригдлаа. Дээрх хэрэг олон улсын мэдээллийн вебсайтаар буюу хэрэг болсноос сар гаруйн дараа цацагдсанаас хойш л монголчуудын дунд яригдаж эхэлсэн. Гадаад харилцааны яамнаас ч уг мэдээллийг хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал дээрх хүмүүс нь Истанбул дахь монголын консулын газрын дипломат ажилтан болон жолооч нар байсан гэдгийг мэдэгдсэн.

### Дүгнэлт тайлбар:

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан байгаа нэр бол Баттүшиг консул, Эрдэнэбаяр жолооч гэсэн байгаа. Энэ бүхэн уг нь сарын өмнө болсон юм билээ. 6-р сарын 6-нд [www.akipress.com](http://www.akipress.com) гэдэг вебсайтад гарсан. Монголын 2 дипломатыг баривчилсан гэж. 140 жижиг хүүдий, 500 гр тус бүрээр нь боогоод машин дотроо авч явсан байгаа юм. Германыхан машиныг нь шалгах гэхээр дипломат паспорт үзүүлээд машинаа цоожлоод байсан. Цагдаа дуудаж байгаад, Германд бүртгэлтэй дипломатууд биш гээд шалгаад олсон юм байна.

Энэ бол манай авлигатай төр засгаас заавал гарч ирэх ёстой муухай жимс нь л дээ. Гадаад харилцааны яам, гадаадад байгаа элчин сайдын яамд улс төрийн томоохон албан тушаал хашигчид, тэдний хамаатан саднаар дүүрч дипломат паспортыг гэмт хэргийн халхавч гэж ойлгосон этгээдүүд монголын нэр хүндийг яаж унагаж байгааг харууллаа.



Гэрэл зургийг: [www.akipress.com](http://www.akipress.com)

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв  
Тоймын бүрэн эхийг [jargaldefacto.com](http://jargaldefacto.com) вебсайтаас үзэж  
боломжтой.

GOOGLE STORE




APP STORE





**ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС**



**TOTAL QUARTZ 9000  
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ  
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР  
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

**Холбоо барих утас:** 9411-7143, 9906-6402

 [www.minesup.mn](http://www.minesup.mn)

 @TOTALMongolia

 [fb.com/TOTALMongolia](https://fb.com/TOTALMongolia)

 @TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

**UP**  
**MINES**  
www.minesup.mn